



**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,  
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,  
E-mail: info@mrt.d.gov.mn, http://www.mrt.d.gov.mn

2021.02.18 № 07/657  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

**“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” Т  
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ Б.ГҮРСОРОНЗОН  
ТАНАА**

“Тээврийн хэрэгслийн бүртгэлийн системийн үйл ажиллагааг зохицуулах журам шинэчлэн батлах тухай” Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/21 дүгээр тушаалын хуулбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Дээр дурдсан тушаалын хэрэгжилтийг ханган ажиллана уу.

Хавсралт: 7 хуудастай.

АВТОТЭЭВРИЙН БОДЛОГЫН  
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН  
ДАРГА *[Signature]* ЁЖАРГАЛСАЙХАН

1118288063 5919487 СБТ9513

02 000506



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгслийн бүртгэлийн системийн  
үйл ажиллагааг зохицуулах журам шинэчлэн  
батлах тухай

"Монгол Улсын Засгийн газрын тухай" хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай" хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, "Автотээврийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.11 болон 6.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Тээврийн хэрэгслийн бүртгэлийн системийн үйл ажиллагааг зохицуулах журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү журмыг мөрдөж ажиллахыг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ё.Жаргалсайхан/, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ /Б.Гүрсоронзон/-т тус тус даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн сайдын 2015 оны 296 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Л.ХАЛТАР

Зам, тээврийн хөгжлийн байдлын 2021  
оны 2 дугаар сарын 18 ны өдрийн  
12/21 дугаар тушаалын хавсралт



## ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛИЙН СИСТЕМ ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр замын хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах, мэдээллийн сан, мэдээлэл солилцох системийн аюулгүй байдал, найдвартай ажиллагааг хангах, бүртгэлийн үйл ажиллагааг хурдан шуурхай зохион байгуулах, сайжруулахад оршино.

1.1.1. "бүртгэлийн систем" гэж тээврийн хэрэгслийн бүртгэлийн програм, өгөгдлийн сан, сервер сүлжээ бүхий цогц системийг;

1.1.2. "бүртгэлийн програм" гэж тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагааг зохион байгуулахад ашиглаж буй вэб хандалт бүхий програм хангамжийг;

1.1.3. "улсын бүртгэлийн дугаар захиалгын програм" гэж автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар захиалга хийх вэб хандалт бүхий програм хангамжийг;

1.1.4. "дуудлага худалдааны програм" гэж автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг үнэ хаялцуулах замаар худалдан борлуулах вэб хандалт бүхий програм хангамжийг;

1.1.5. "улсын дугаарын үйлдвэрийн програм" гэж тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн бүртгэл, тэмдэгт үйлдвэрлэх эрхийг зохицуулах вэб хандалт бүхий програм хангамжийг;

1.1.6. "мэдээллийн сан" гэж бүртгэлийн системийн цуглуулсан тээврийн хэрэгсэл ба түүний өмчлөгч, эзэмшигчийн тухай бүх төрлийн мэдээллийг агуулж буй өгөгдлийн санг;

1.1.7. "эрх бүхий хэрэглэгч" гэж бүртгэлийн системд нэвтэрч буй албан хаагчийг тус тус ойлгоно.

### Хоёр. Бүртгэлийн системийн үндсэн чиглэл

2.1. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн системийн үйл ажиллагаанд нэвтрэх эрх бүхий хэрэглэгчийг дараах байдлаар ангилна.

2.1.1. Систем администратор эрх бүхий хэрэглэгч

2.1.2. Админ эрх бүхий хэрэглэгч

2.1.3. Зохицуулалтын эрх бүхий хэрэглэгч

2.1.4. Хяналтын эрх бүхий хэрэглэгч

2.1.5. Системийн хөгжүүлэлт хийх эрх бүхий хэрэглэгч

2.1.6. Улсын дугаарын үйлдвэрүүдийн хяналт бүхий хэрэглэгч

2.1.7. Бүртгэлийн системийн үйлчилгээний эрх бүхий хэрэглэгч

2.2. Систем администратор эрх бүхий хэрэглэгч нь автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан тушаалтан байх бөгөөд дарах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.2.1. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн системд систем админ эрхээр нэвтэрч буй бүртгэлийн системийн хэвийн үйл ажиллагааг хангах;

2.2.2. Шаардлагатай тохиолдолд өгөгдлийн сангаас мэдээлэл боловсруулалт хийх;

2.2.3. Бүртгэлийн системд хандах гадны хууль бус нэвтрэлт, бүртгэлийн системийг зүй бусаар ашиглах, өгөгдлийн сангийн аюулгүй байдлыг хангах;

2.2.4. Улсын дугаарын шинэ сери үүсгэх, илгээх, тээврийн хэрэгслийн бүртгэлийн системд тавигдах ерөнхий шаардлагыг хангуулах;

2.2.5. Системийн хөгжүүлэлтийг хийх үйл явцад хяналт тавих;

2.3. Админ эрх бүхий хэрэглэгч нь тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллагын албан тушаалтан байх бөгөөд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.3.1. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн системд админ эрхээр нэвтэрч буй мэдээллийн сангийн хуулбар үүсгэх;

2.3.2. техникийн хяналт, үзлэгийн мэдээллийн санг бүртгэлийн мэдээллийн сантай холболт хийх;

2.4. Зохицуулалтын эрх бүхий хэрэглэгч нь тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллагын бүртгэлийн нэгжийн удирдах албан тушаалтан байх бөгөөд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.3.1. тээврийн хэрэгслийн бүртгэлийн програмыг хэрэглэгчдийн бүртгэл хөтлөх;

2.3.2. програмд хандах эрхийг зохицуулах;

2.3.3. тээврийн хэрэгслийн бүртгэлийн програмаас бүх төрлийн тайлан, мэдээлэл, лавлагааг гарган авах;

2.3.4. хэрэглэгчдийн хийсэн үйлдлийн тайлан/аудит лог/-г хянах;

2.3.5. улсын дугаарын серийг дугаар захиалгын програмын захиалгын дэлгэцэнд гаргах эсэхийг тохируулах;

2.5. Хяналтын эрх бүхий хэрэглэгч нь тээврийн хэрэгслийн бүртгэлийн програмд нэвтэрч буй тээврийн хэрэгслийн бүртгэлийн системээс тээврийн хэрэгслийн мэдээлэл, мэргэжилтний тайланг албан ажлын шаардлагын дагуу хяналт хийх зорилгоор харах эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагын болон тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллагын удирдах албан тушаалтан, Авилгатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын /Төрийн тусгай байгууллагын/ албан тушаалтан байна.

2.6. Системийн хөгжүүлэлт хийх эрх бүхий хэрэглэгч нь бүртгэлийн системийг хөгжүүлэх ажлын даалгаварт тусгагдсан үйлчилгээг нэмж хөгжүүлэх болон системд байгаа алдааг засах эрх бүхий нууцын баталгаа гаргасан тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллагын албан тушаалтан эсхүл гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байна.

- 2.7. Улсын дугаарын үйлдвэрүүдийн хяналт бүхий хэрэглэгч нь автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан тушаалтан байх бөгөөд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 2.7.1. тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих;
- 2.7.2. дугаарын үйлдвэрийн програмд нэвтрэх, хандах эрхийг зохицуулах;
- 2.8. Улсын дугаарын үйлдвэрийн эрх бүхий хэрэглэгч нь тээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн ажилтан байх бөгөөд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 2.8.1. Үйлдвэрлэх боломжтой дугаарын жагсаалтыг харах;
- 2.8.2. Дугаарын дэвсгэр өнгийг тохируулж хэвлэх;
- 2.9. Бүртгэлийн системийн үйлчилгээний эрх бүхий хэрэглэгч нь тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллагын бүртгэлийн нэгжийн албан тушаалтан байх бөгөөд тээврийн хэрэгслийн бүртгэлийн програмд нэвтэрч буй зохицуулалтын эрх бүхий хэрэглэгчээс өгсөн дараах эрхтэй байна. Үүнд:
- 2.9.1. "Импорт эрх" нь Монгол Улсад импортоор орж ирсэн тээврийн хэрэгслийг техникийн үзлэг, хяналтын мэдээллийн сангаар дамжин ирсэн мэдээллийн дагуу бүртгэж улсын дугаар, гэрчилгээ олгох, тайлан гаргах болон холбогдох баримт бичгийг архивлах;
- 2.9.2. "Өмчлөгч шилжүүлэх эрх" нь тээврийн хэрэгслийн бүртгэлийн системд нэвтэрч буй Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгслийн өмчлөлийн өөрчлөлтийг тухай бүрд нь үнэн зөв бүртгэн тайлан гаргах, холбогдох баримт бичиг архивлах;
- 2.9.3. "Улсын дугаар солилттой шилжилт эрх" нь тээврийн хэрэгслийг шилжүүлэхэд өмчлөгчийн харъяаллаас хамаарч улсын дугаарыг сольж бүртгэл хөтлөх;
- 2.9.4. "Гэрчилгээ нөхөн олголт, гэрчилгээ солилт, тэмдэгт нөхөн олгох эрх" нь тээврийн хэрэгслийн бүртгэлийн системд нэвтэрч буй тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаараа хаясан, гэсэн, үрэгдүүлсэн мэдээллийг үндэслэн нөхөн олголт хийж, тайлан гаргах болон холбогдох баримт бичиг архивлах;
- 2.9.5. "Хязгаарлах эрх" нь тээврийн хэрэгслийн бүртгэлийн системд нэвтэрч буй тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнд хязгаарлалт хийх бөгөөд зөвхөн шүүх, прокурорын холбогдох зөвшөөрлөөр хязгаарлалт хийж тайлан гаргах;
- 2.9.6. "Тайлан эрх" нь тээврийн хэрэгслийн бүртгэлийн системд нэвтэрч буй бүртгэлийн системээс гарч болох бүх төрлийн тайланг нэгтгэн гаргаж, үнэн зөв судалгаа статистик мэдээллээр холбогдох удирдлагууд болон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах;
- 2.9.7. "Серийн лавлах эрх" нь улсын дугаарын нийт серийг харах, тухайн серийн дугаарын олгогдсон эсэхийг харах, орон нутгийн дугааруудыг хэсэгчлэн илгээх, буцаан татах эрх;
- 2.9.8. "Хаягийн лавлах эрх" нь улс, хот аймаг, сум, дүүрэг, баг, хороо, хорооллын мэдээлэл харах эрх;

2.9.9. "Хасалт хийх эрх" нь тээврийн хэрэгслийн бүртгэлийн системд нэвтэрч буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн хүсэлтийн дагуу тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасах

2.9.10. "Хасалтаас сэргээх эрх" нь тээврийн хэрэгслийн бүртгэлийн системд нэвтэрч буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирсэн хүсэлтийн дагуу хасагдсан тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд сэргээх;

2.9.11. "Тээврийн хэрэгсэл идэвхжүүлэх эрх" нь Идэвхгүй төлөв /Техникийн хяналтын үзлэгт сүүлийн 5 жил ороогүй, тээврийн хэрэгслийн татварыг сүүлийн 5 жилд төлөөгүй/-т байгаа тээврийн хэрэгслийг идэвхжүүлэх буюу тухайн тээврийн хэрэгсэлтэй холбоотой үйлчилгээний эрхийг нээх;

2.9.12. "Засварлах эрх" нь тээврийн хэрэгслийн бүртгэлийн системд алдаатай болон ташаа мэдээллийг баримт бичиг үндэслэн тухай бүр засварлаж үнэн зөв болгох, шаардлагатай мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулах, системд аж ахуйн нэгж байгууллагын салбар нээх ба програмчлалын алдаа гарвал систем администраторт хандан алдааг залруулах;

2.9.13. "ДК эрх" гэж гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын хүсэлтээр дипломат байгууллагын тээврийн хэрэгсэлд "ДК" сери бүхий дугаар олгох, солих эрх;

2.9.14. "Улсын дугаар солилтын эрх" нь тээврийн хэрэгслийн өмчлөгчийн хүсэлтээр улсын бүртгэлийн дугаар захиалгын програмаас захиалсан дугаараар солих эрх;

2.9.15. "Тээврийн хэрэгсэл хоорондын дугаар солилтын эрх" гэж тээврийн хэрэгслийн өмчлөгчдийн хүсэлтээр хоёр тээврийн хэрэгслийн дугаарыг хооронд нь солих эрх

2.9.16. "Эзэмшигч бүртгэх эрх" гэж тээврийн хэрэгсэл өмчилж байгаагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийг бүртгэлийн програмд шинээр оруулах, хуучин бүртгэлтэй эзэмшигчдийн мэдээллийг засварлах.

### **Гурав. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн системийн үйл ажиллагааны зохион байгуулалт**

3.1. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн үндсэн мэдээллийн сан нь "Үндэсний дата төв" УТҮГ-ын мэдээллийн төвд техникийн хяналтын үзлэгийн системийн мэдээллийн сангийн хамт байрших бөгөөд уг мэдээллийн сангийн хуулбарыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллагын нөөц сервер, "Үндэсний дата төв" УТҮГ-ын төрийн үйлчилгээний Exedata-д байршуулна.

3.2. Бүртгэлийн систем нь тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны харилцан уялдааг хангах, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх мэдээллийн нэгдсэн сан байна.

3.3. Бүртгэлийн системийг хариуцан ажиллаж буй ажилтан, албан хаагчид нь мэдээллийн сангийн үнэн зөв байдлыг хариуцаж, мэдээллийг тогтмол шинэчлэн хөтөлнө.

3.4. Мэдээллийн сан нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хүрээнд баримт бичгийн шаардлага хангасан тээврийн хэрэгслийн цахим

мэдээллийн бүрдэл байх бөгөөд байгууллага, иргэд, аж ахуйн нэгжүүдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр шуурхай хангана.

3.5. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн мэдээллийг бусад байгууллагад цахимаар дамжуулахдаа "ХУР" төрийн мэдээлэл солилцооны системийг ашиглана.

3.6. Иргэнд өөрт нь хамаарах тээврийн хэрэгслийн мэдээллийг цахимаар дамжуулахдаа "Үндэсний дата төв" УТҮГ-т байрлах "ДАН" системийг ашиглана.

3.7. Иргэн, байгууллагын хүсэлтийг үндэслэн тээврийн хэрэгслийн бүртгэлийн хэрэгцээт мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бүртгэлийн програм, мэдээллийн санг ашиглан хүргэнэ.

3.8. Нууцын зэрэглэлтэй мэдээллийг Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журамд заасны дагуу хамгаална.

3.9. Тээврийн хэрэгслийн улсын дугаарыг иргэн, аж ахуйн нэгж байгууллага улсын бүртгэлийн дугаар захиалгын програмаас сонгож, өмчлөгчийн регистрийн дугаар, тээврийн хэрэгслийн арлын дугаарын сүүлийн 5 тэмдэгтийг үнэн зөв оруулж захиалах ба захиалгын мэдээллийг бүртгэлийн програмаас шалгана.

3.10. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн програм нь үнэ хаялцуулах замаар худалдан борлуулах дугаарын мэдээллийг дуудлага худалдааны програмтай солилцоно.

#### **Дөрөв. Бүртгэлийн системд тавигдах шаардлага**

4.1. Бүртгэлийн систем нь дараах ерөнхий шаардлага хангасан байна:

4.1.1. Бүртгэлийн системийн мэдээлэл, лавлагаа, тайлан нь цаг үедээ нийцсэн, хууль ёсны, үнэн зөв, бодитой байх;

4.1.2. Бүртгэлийн системийн мэдээ мэдээлэл, үйлчилгээ, бусад хэсгүүд болон дэд бүтцийн элементүүд нь санаатай болон санамсаргүй үйлдэл, хууль бус нэвтрэлт, зүй бусаар ашиглах, өөрчлөх, устгах гэмтэхээс найдвартай хамгаалагдсан байх;

4.1.3. Бүртгэлийн програм нь хэрэглэгчдийн хийсэн үйлдлийн тайлан/аудит лог/-тай байна.

4.1.4. Бүртгэлийн системийн интерфейс нь орчин үеийн мэдээллийн технологийн ололтод тулгуурласан, хэрэглэгч ашиглахад хялбар энгийн, ойлгомжтой байна.

4.1.5. Систем бүхэлдээ ISO/27001 стандартын шаардлага хангасан байна.

4.1.6. Бүртгэлийн системд архивын материалыг "PDF" файл болгон цахим хэлбэрээр хадгална.

#### **Тав. Системийн хөгжүүлэлт, нууцлал, аюулгүй байдал**

5.1. Системийн хөгжүүлэлтийг автотээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан ажлын даалгаврын дагуу тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллага хариуцан зохион байгуулна.

5.2. Тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллага нь дараах үүрэгтэй. Үүнд:

5.2.1. системийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг системийн хэрэглэгчдээс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн тухай бүр тодорхойлж, ажлын даалгавар бэлдэх, хөгжүүлэлтийн явцад хяналт тавьж ажиллана.

5.2.2. системийн нууцлал, аюулгүй байдлыг хангах үүднээс жил бүр эсхүл системд томоохон хөгжүүлэлт хийсний дараа Тагнуулын ерөнхий газрын харьяа Мэдээллийн аюулгүй байдлын газарт хүсэлт тавин дүгнэлт гаргуулж, ирүүлсэн зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.

5.2.3. систем хөгжүүлэлтийг програмын туршилтын хувилбар болон мэдээллийн сангийн хуулбар дээр хийж туршсаны дараа зохих зөвшөөрлийг авч системийн үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.

5.2.4. мэдээллийн сангийн хуулбарыг өдөр бүр авч байх ба шаардлагатай тохиолдолд хуулбар нөөцийг сэргээж магадлан шалгах тогтолцоог бүрдүүлсэн байна.

5.3. Бүртгэлийн системийн үйл ажиллагаа, бүртгэлийн мэдээллийн сангийн аюулгүй байдлыг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хангаж ажиллана.

5.4. Бүртгэлийн системийн хөгжүүлэлт, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн мэдээллийн сангийн аюулгүй байдал, өдөр тутмын найдвартай ажиллагааг тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллага хангаж ажиллана.

5.5. Бүртгэлийн системийн үйл ажиллагаанд шууд хамаарал бүхий бусад системийн хэвийн ажиллагаа, систем хоорондын уялдаа холбоог тухайн асуудал хариуцсан байгууллага, албан тушаалтан хангаж ажиллана.

### **Зургаа. Бусад**

6.1. Энэхүү журмын 2.2-2.7-д заасан эрх бүхий хэрэглэгчид нь 2.8 ба 2.9-д заасан эрхтэй байхыг хориглоно.

6.2. Бүртгэлийн системд оруулсан тээврийн хэрэгслийн мэдээ, мэдээллийн үнэн зөв эсэхийг тухайн мэдээллийг оруулсан тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх эрх бүхий байгууллагын мэргэжилтэн хариуцах, мөн үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн, удирдах албан тушаалтан хяналт тавина.

6.3. Бүртгэлийн програмд нэвтрэх эрхээ бусдад дамжуулахыг хориглоно.

6.4. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн системийн үйл ажиллагаанд төрийн захиргааны төв байгууллагаас хяналт тавина.

6.5. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.